



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/7

Чойр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар 43.1, 43.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Газрын албан үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой болон Газрын харилцааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж чанартай үр дүнтэй зохион байгуулалт хийж ажиллахыг хэлтсийн дарга (Э.Баярмагнай, Б.Даваажаргал) нарт даалгасугай.


ДАРГА



Б.ОТГОНЧИМЭГ

4210000061

Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын даргын 2023 оны 04 дугаар
сарын 20 өдрийн 1/2 дүгээр тушаалын хавсралт



**"НЭЭЛТТЭЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА 20 ЖИЛ"
ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	Аймгийн хэмжээнд "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгуулах.	Сүмбэр сум	2023.05.04-06	Газрын удирдлагын хэлтэс
		Шивээговь сум	2023.05.10-ны дотор	
		Баянтал сум	2023.05.10-ны дотор	
2	"АХА" тэмцээнийг зохион байгуулах.	Сумдуудад	2023.05.10-ны дотор	Сумдын газрын даамлууд
3	2023 оны сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг иргэд олон нийтэд сурталчлах	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 хоногийн тойм мэдээний ярилцлагад орох.	2023.05.05-ны дотор	Д.Ганзориг
4	Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт сургалт хийх	Газрын тухай хууль тогтоомжинд заасан эрх, үүрэг, тулгамдсан асуудалын талаар сургалт зохион байгуулана.	2 дугаар улиралд	Д.Ганзориг, тухайн сумын газрын даамал
5	Албан байгууллагуудад газрын харилцааны хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийх	Хуваарь гарган албан хаагчид хариуцсан байгууллагуудад мэдээлэл хийх	05 дугаар сарын 10-ны дотор	Газрын удирдлагын хэлтэс
6	Хөдөөгийн багийн Иргэдийн Нийтийн Хуралд оролцож, мэдээлэл хүргэн гарын авлага тараах.	Хөдөөгийн 5 багийн өдөрлөгт оролцож мэдээлэл хийнэ.	5 дугаар сарын 10-ны дотор	
7	Газрын харилцааны ажилтны өдрийг угтан байгууллагаараа "Цусаа хандивлах" аянд нэгдэж цусаа өгөх	Байгууллагын бүх албан хаагчид цусаа хандивлах	2023.05.01-ний дотор	Бүх албан хаагч
8	20 жилийн ойг угтан байгууллагын хуваарьт талбайд мод тарих	50 ширхэг мод тарьж ойн ангид хүлээлгэн өгөх	2023.05.10 -ны дотор	
9	Газрын харилцааны үйл ажиллагаа онцлог, түүхэн өөрчлөлт, шинэчлэлтийн талаар видео мэдээлэл бэлтгэх	Видео мэдээлэлийн төлөвлөгөө гаргаж бэлтгэх	2023.05.01-ний дотор	Хэлтсийн дарга нар
10	Байгууллагын түүхэн онцлогийг харуулсан сэтгүүл гаргах	Байгууллагын түүхийг илтгэсэн сэтгүүл бэлтгэн хэвлүүлж танилцуулах	2023.05.05-ны дотор	Хэлтсийн дарга нар

БОЛОВСРУУЛСАН

Э.БАЯРМАГНАЙ

/ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА/